



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/НБ

Амардалай

Залуучуудын өдөрлөг арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.5, 27.5.8, 27.5.9, 59 дүгээр зүйлийн 59.1.8, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын санал санаачилгыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгах, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулан, орлогын эх үүсвэрийг дэмжих, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "Залуу нас-Оргил цаг" өдөрлөг арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Өдөрлөг арга хэмжээний хөтөлбөр, удирдамжийг батлуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган үйл ажиллагааг чанартай сайн зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Л.Золжаргал), Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3. Залуучуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэхэд, баг хамт олноо нэгдсэн удирдлагаар хангаж, мэдээлэл хүргэн ажиллахыг байгууллагын удирдлагууд болон багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Өдөрлөг арга хэмжээнд шаардагдах 1,000,000 (Нэг сая) төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүгийн холбогдох баримт бүрдүүлэхийг ЗДТГ-ын нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

2022.06.15 50